



БАГАНУУР ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



---

Танаа

## БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

/2016 оны 4-р улирал/

/Албан ёсны статистик мэдээллээр бэлтгэсэн танилцуулга/

2017 он

## ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

## Хүснэгт 1. 2016 оны жилийн эцсийн байдлаар

/урьдчилсан байдлаар/

Үзүүлэлт	Хэмжих нэгж	1 хороо	2 хороо	3 хороо	4 хороо	5 хороо	Дүүргийн дүн
Малын тоо	Тоо	52207	11838	43939	45843	24947	178774
Үүнээс: Тэмээ	Тоо	72	-	135	2	-	209
Адуу	Тоо	4568	724	3174	3168	2409	14043
Үхэр	Тоо	4318	1143	3204	3461	2072	14198
Хонь	Тоо	26332	6028	22823	23922	12166	91271
Ямаа	Тоо	16917	3943	14603	15290	8300	59053

## Хүснэгт 2. Жил бүрийн тайлант хугацаанд

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Суурин хүн ам	Тоо	25875	26905	27036	27440	27936	28333	28419	28973 <sup>1</sup>
Төрөлт	Тоо	671	631	657	753	850	765	722	606
Нас баралт	Тоо	136	169	200	148	176	194	188	169
Шилжиж ирсэн	Тоо	1048	1383	893	719	1280	1139	1196	1036
Шилжиж явсан	Тоо	1585	1732	1218	920	1383	1365	1438	1325
Бүртгэлтэй ажилгүй иргэд	Тоо	800	754	486	357	311	418	589	579
Халдварт өвчин	Тоо	565	564	615	542	539	487	543	798
Бүртгэгдсэн гэмт хэрэг	Тоо	293	251	218	278	278	236	311	297


<sup>1</sup> – урьдчилсан байдлаар

**АЖ ҮЙЛДВЭР:** Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт тайлант хугацаанд 112.6 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 6.2 хувиар буюу 6.6 тэрбум төгрөгөөр өссөн байна.


Хүснэгт 3. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт

Үзүүлэлт	Нийт үйлдвэрлэлт /биет хэмжээгээр/			Нийт үйлдвэрлэлт /үнийн дүнгээр, мянган төгрөг/		
	2015 он	2016 он	өсөлт бууралт	2015 он	2016 он	өсөлт бууралт
Нүүрс олборлолт	3731.2	3913.8	182.6	95145600.0	107629500.0	12483900.0
Дулаан дамжуулалт	153.2	155.9	2.7	3666831.8	4505054.6	838222.8
Талх үйлдвэрлэлт	119.3	128.3	9.0	151425.5	167012.6	15587.1
Нарийн боов үйлдвэрлэлт	170.8	162.9	-7.9	347782.1	321216.4	-26565.7
Арматур	8100	-	-	6723000.0	-	-

Зураг 1. Нүүрс олборлолт /сараар/



Зураг 2. Нүүрс олборлолт, мян.тн



Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт /биет хэмжээгээр/ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нүүрс олборлолт 4.9 хувиар буюу 182.6 мянган тонноор, дулаан дамжуулалт 1.8 хувиар буюу 2.7 мянган гкал-аар, талх үйлдвэрлэлт 7.5 хувиар буюу 9.0 тонноор тус тус өссөн бол нарийн боов үйлдвэрлэлт 4.6 хувиар буюу 7.9 тонноор буурсан байна. Тайлант хугацаанд барилгын арматур үйлдвэрлэгдээгүй байна.

Зураг 3. Талх, нарийн боов үйлдвэрлэлт, тн



Харин аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг үнийн дүнгээр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нүүрс олборлолт 13.1 хувиар буюу 12483.9 сая төгрөгөөр, дулаан дамжуулалт 22.9 хувиар буюу 838.2 сая төгрөгөөр, талх үйлдвэрлэлт 10.3 хувиар буюу 15.6 сая төгрөгөөр тус тус өссөн бол нарийн боов үйлдвэрлэлт 7.6 хувиар буюу 26.6 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

**НИЙГМИЙН ДААТГАЛ:** 2016 онд нийгмийн даатгалын сангийн орлого 12264.1 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 2.3 хувиар буюу 272.7 сая төгрөгөөр, зарлага 21787.6 сая төгрөг болж 9.8 хувиар буюу 1945.6 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Нийт орлогын 59.5 хувь буюу 7293.0 сая төгрөгийг тэтгэврийн сангаас, 6.6 хувь буюу 815.5 сая төгрөгийг тэтгэмжийн сангаас, 10.5 хувь буюу 1287.1 сая төгрөгийг ҮОМШӨ сангаас, 21.7 хувь буюу 2667.0 сая төгрөг нь эрүүл мэндийн даатгалын сангаас, 1.6 хувь буюу 201.5 сая төгрөг ажилгүйдлийн сангаас тус тус төвлөрсөн байна.


Зураг 4. Нийгмийн даатгалын сангийн орлого



Хүснэгт 4. Нийгмийн даатгалын сангийн орлого, зардал

Үзүүлэлт	2015 он		2016 он	
	Хүний тоо	Сая төгрөг	Хүний тоо	Сая төгрөг
Сангийн орлого бүгд		11991.4		12264.1
үүнээс: тэтгэврийн сан		7387.7		7293.0
тэтгэмжийн сан		825.5		815.5
ажилгүйдлийн сан		204.3		201.5
ҮОМШӨ-ний сан		1303.8		1287.1
ЭМД-ын сан		2270.1		2667.0
Сангийн зарлага бүгд		19832.0		21787.6
үүнээс: тэтгэврийн сан	3870	13389.4	3993	14935.4
тэтгэмжийн сан	2862	781.2	3188	810.2
ажилгүйдлийн сан	182	211.6	241	353.0
ҮОМШӨ-ний сан	1286	1930.7	1005	1890.0
ЭМД-ын сан	133774	3519.1	127434	3799.0


Зураг 5. Нийгмийн даатгалын сангийн зарлагын бүтэц /хувиар/



Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангаас 3993 хүнд 14935.4 сая төгрөгийн тэтгэвэр, 3188 хүнд 810.2 сая төгрөгийн тэтгэмж, 241 хүнд 353.0 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж, 1005 хүнд 1890.0 сая төгрөгийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэмж, 127434 хүнд 3799.0 сая төгрөгийн эрүүл мэндийн даатгал тус тус олгосон байна.

**НИЙГМИЙН ХАЛАМЖ:** 2016 оны байдлаар нийгмийн халамжийн сангийн орлого 2324.6 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 1.7 хувиар буюу 39.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийт орлогын 348.0 сая төгрөг буюу 15.0 хувь нь улсын төсвөөс, 1970.4 сая төгрөг буюу 84.8 хувь нь орон нутгийн төсвөөс, 6.2 сая төгрөг буюу 0.3 хувь нь бусад орлогоор тус тус санхүүжигдсэн байна.



Хүснэгт 5. Нийгмийн халамжийн сангийн орлого, зардал


Үзүүлэлт		2015 он		2016 он	
		Мян төг	Хүний тоо	Мян төг	Хүний тоо
Нийгмийн халамжийн сангийн орлого		2285281.0		2324616.4	
Үүнээс:	Улсын төсвөөс	348000.0		348000.0	
	Орон нутгийн төсвөөс	1931872.4		1970414.3	
	Бусад орлого	5408.6		6202.1	
Нийгмийн халамжийн сангийн зарлага		2270463.0		2304218.6	
Үүнээс:	Тэтгэвэр	722729.4	480	746656.8	522
	Тэтгэмж	345430.6	552	399710.7	790
	"Алдарт эх" 1 одонтой эхчүүд	150600.0	753	144800.0	724
	"Алдарт эх" 2 одонтой эхчүүд	129100.0	1291	135000.0	1350
	Жирэмсэн эхчүүдийн тэтгэмж	323851.9	667	304802.5	665
	Ахмад дайчин, гавьяатын нэмэгдэл	43813.1	20	42285.0	20
	Ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт	244924.5	2379	221581.7	1841
	ХБИргэнд үзүүлсэн хөнгөлөлт	129362.5	678	107349.6	641
	ОНО-д түшиглэсэн халамжийн үйлчилгээ	3936.0	36	12000.0	14
	"Хүнс тэжээл" халамжийн хөтөлбөр	140752.1	1200	145086.0	1200
	Бусад үйлчилгээ	35962.9		44946.3	

Тайлант хугацаанд нийгмийн халамжийн сангаас 522 хүнд 746.7 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, 790 хүнд 399.7 сая төгрөгийн тэтгэмж, “Алдарт эх”-ийн одонтой 2074 хүнд 279.8 сая төгрөг, 665 жирэмсэн эхчүүдэд 304.8 сая төгрөгийн тэтгэмж, 20 ахмад дайчин, гавьяат цолтой хүнд 42.3 сая төгрөг, 1841 ахмад настанд 221.6 сая төгрөгийн хөнгөлөлт, 641 хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 107.3 сая төгрөгийн хөнгөлөлт тус тус олгосон байна.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 14 иргэд 12.0 сая төгрөг, “Хүнс тэжээл” халамжийн хөтөлбөрийн хүрээнд 1200 иргэнд хамрагдаж 145.1 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон байна.

**НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ:** Тайлант хугацаанд нийтийн аж ахуй үйлчилгээний салбарын нийт орлого 1608.5 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеийнхээс 12.7 хувиар буюу 234.9 сая төгрөгөөр буурсан байна. Нийт орлогын 982.5 сая төгрөг буюу 61.1 хувь нь хүн амаас оруулсан орлого эзэлж байна.

Зураг 7. Орлогын төлөвлөгөөний биелэлт



Хүснэгт 6. Орон сууц нийтийн аж ахуйн орлогын байдал.

мянган төгрөг

Үзүүлэлт	2015 он	2016 он	Өсөлт бууралт
Орон сууц	115399.0	127808.0	12409.0
Ус борлуулалт-бүгд	781817.8	748911.2	-32906.6
үүнээс: хүн амд	439206.9	406225.0	-32981.9
аж ахуйн нэгжид	326325.8	328878.0	2552.2
үйлчилгээний байгууллагад	16285.2	13808.2	-2477.0
Сувагжуулалт	614570.9	589183.9	-25387.0
Бусад	331574.3	142594.2	-188980.1
Дүн	1843362.1	1608497.3	-234864.8

**СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБОО:**

2016 оны байдлаар дүүргийн сууц өмчлөгчдийн

холбоодын орлогын төлөвлөгөөний биелэлт доорх байдалтай байна.

Хүснэгт 7. Сууц өмчлөгчдийн холбоодын орлогын байдал.

мянган төгрөг

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ТБ%
Тавлаг өргөө	82019.5	72022.8	87.8
Маргад өргөө	56400.0	58792.7	104.2
Сод хөгжил	72379.9	69536.8	96.1
Шинэ элч	63147.1	61388.1	97.2
Уурхайчин	51408.0	42775.7	83.2
НИЙТ ДҮН	325354.5	304516.1	93.6

**ТЭЭВЭР:**

Автотээврийн салбарын орлого 2016 оны 4-р улирлын байдлаар 866.5 сая

төгрөг байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 15.6 хувиар буюу 158.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Тээврийн салбарын үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2014 он	2015 он	2016 он	Өсөлт бууралт
Нийт орлого \мян төг\	674165.8	1025134.8	866503.3	-158631.5
Тээсэн зорчигч \мян хүн\	197.7	186.1	202.7	16.6
Зорчигч эргэлт \мян хүн км\	26689.5	25123.5	27364.5	2241.0

Тайлант хугацаанд автотээврээр давхардсан тоогоор 202.7 мянган зорчигч тээвэрлэж, 27364.5 мянган хүн километрийн ажил үйлчилгээг гүйцэтгэсэн нь өнгөрсөн оны мөн үеэс зорчигчдын тоо 8.9 хувиар буюу 16.6 мянган хүнээр, зорчигч эргэлт 8.9 хувиар буюу 2241.0 мянган хүн километрээр тус тус өссөн байна.

**ШУУДАН ХОЛБОО:** Шуудан холбооны үйлчилгээний орлого 2016 оны 4-р улиралд 382.9 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 8.6 хувиар буюу 36.1 сая төгрөгөөр, хүн амаас орсон орлого 216.2 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 15.7 хувиар буюу 40.3 сая төгрөгөөр тус тус буурсан байна. Нийт орлогын 56.5 хувийг хүн амаас орсон орлого эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 4.7 пунктээр буурсан байна.

Хүснэгт 9. Шуудан холбооны үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	2014 он	2015 он	2016 он	өөрчлөлт
Холбооны үйлчилгээний орлого, мян.төг	499343.0	419021.6	382889.3	-36132.3
Үүнээс: хүн амаас орсон орлого	285960.2	256528.4	216221.8	-40306.6
Суурин телефон цэг	723	652	703	51
Үүнээс айл өрхийн	305	235	299	64

Зураг 8. Суурин телефон хэрэглэгчдийн тоо



Тайлант хугацаанд суурин телефон хэрэглэгчдийн тоо 703 байгаагаас 42.5 хувь буюу 299 нь айл өрхийн хэрэглэгчид байна.

Шуудангийн үйлчилгээний салбар 2016 оны 4-р улиралд 13.5 мянган ширхэг бичиг захидал, 1.5 мянган ширхэг илгээмж, 288.0 мянган ширхэг тогтмол хэвлэлийг хэрэглэгчдэд хүргэсэн байна.

**ЭРҮҮЛ МЭНД:** Дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн мэдээгээр энэ онд 695 эх амаржиж, 700 хүүхэд төрүүлснээс гадны 181 эх амаржсан байна. Энэ хугацаанд 104639 хүн амбульторын үзлэгт хамрагдсан нь өнгөрсөн оны мөн үеэс 13861 хүнээр буюу 11.7 хувиар буурсан байна. Харин 8090 хүн хэвтэн эмчлүүлсэн байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 601 хүнээр буюу 8.0 хувиар өссөн байна.

Зураг 9. Халдварт өвчин /сараар/



Хүснэгт 10. Бүртгэгдсэн халдварт өвчин


Үзүүлэлт		2015 он	2016 он	Өсөлт бууралт
Халдварт, паразит өвчин		251	233	-18
Үүнээс:	Заг хүйтэн	107	92	-15
	Тэмбүү	86	73	-13
	Трихомониаз	45	49	4
	Кандидоз /мөөгөнцөр/	7	13	6
	Кандилом	4	5	1
	Халамид	2	1	-1
Цочмог халдварт өвчин		292	565	273
Үүнээс:	Цусан суулга	6	6	0
	Гепатит А	8	7	-1
	Салхин цэцэг	185	84	-101
	Гахай хавдар	1	1	0
	Гар хөл амны өвчин	16	67	51
	Корь	24	354	330
	Сепсис	2	-	-2
	Хачигт рикеттиоз	1	2	1
	Роже	6	3	-3
	Боом	1	-	-1
	Скарлатан /улаан эсэргэнэ/	4	11	7
	Сүрьеэ	38	26	-12
	Краснух	-	4	4
	Нийт халдварт өвчин		543	798

2016 оны байдлаар халдварт паразит өвчин 233 болж нийт халдварт өвчний 29.2 хувийг эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 18 тохиолдлоор буюу 7.2 хувиар буурсан бол цочмог халдварт өвчин 565 тохиолдол байгаа нь нийт халдварт өвчний 70.8 хувийг эзэлж, өнгөрсөн оны мөн үеэс 273 тохиолдлоор буюу 1.9 дахин өссөн байна. Тайлант хугацаанд корь өвчин 354 бүртгэгдсэн байгаа нь өмнөх оны мөн үеэс 14.8 дахин өссөн байна.

Дүүргийн дунджаар 10000 хүн тутамд ногдох халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо 280.8 байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 87.8 продицмиллээр өссөн байна.

**ГЭМТ ХЭРЭГ:** 2016 оны 4-р улиралд дүүрэгт 297 гэмт хэрэг бүртгэгдсэн байгаа нь өмнөх оны мөн үеэс 4.5 хувиар буюу 14 хэргээр буурсан бол хэрэг илрүүлэлт 73.0 хувь болж өнгөрсөн оны мөн үеэс 1.3 пунктээр нэмэгдсэн байна.

Зураг 10. Бүртгэгдсэн гэмт хэрэг /сараар/





Хүснэгт 11. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг төрлөөр

Хэргийн төрөл	Хэргийн тоо		Хэргийн өсөлт	Дүнд эзлэх хувь
	2015 он	2016 он		
Хүн амь	2	1	-1	0.3
Хүчин	2	7	5	2.4
Дээрэм	3	3	-	1.0
Танхай	13	13	-	4.4
ББМГУчруулах	126	114	-12	38.4
Ашиглах	7	4	-3	1.3
Хулгай	72	71	-1	23.9
<i>үүнээс: малын</i>	<i>7</i>	<i>4</i>	<i>-3</i>	<i>5.6*</i>
Булаалт	-	-	-	-
Залилан	17	12	-5	4.0
ХАБЭсрэг	18	36	18	12.1
Бусад	51	36	-15	12.1
Бүгд	311	297	-14	100.0
Хэрэг илрүүлэлт	71.7	73.0		

\*-малын хулгайн хэргийг нийт хулгайн хэрэгт эзлэх хувиар тооцсон.

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн бүтцийг авч үзэхэд 38.4 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах /ББМГУчруулах/ хэрэг, 23.9 хувийг хулгайн хэрэг, 12.1 хувийг бусад гэмт хэргүүд, 12.1 хувийг хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг /ХАБЭ/ гэмт хэрэг, 4.0 хувийг залилангийн хэрэг, 4.4 хувийг танхайн хэрэг, 2.4 хувийг хүчингийн хэрэг, 1.3 хувийг ашиглах гэмт хэрэг, 1.0 хувийг дээрмийн хэрэг, 0.3 хувийг хүн амины хэрэг тус тус эзэлж байна. Тайлант хугацаанд булаалтын болон гал түймрийн хэргүүд бүртгэгдээгүй бөгөөд малын хулгайн хэрэг 4 бүртгэгдсэн нь нийт хулгайн гэмт хэргийн 5.6 хувийг эзэлж байна.

Зураг 11. Согтуугаар болон гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг



Хүснэгт 12. Согтуугаар болон гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг

Хэргийн төрөл	2015 он		2016 он	
	согтуугаар	гудамж талбайд	согтуугаар	гудамж талбайд
Хүн амь	1	1	1	-
Хүчин	1	-	5	-
Дээрэм	1	-	-	-
Танхай	8	6	10	5

ББМГУчруулах	75	30	66	34
Ашиглах	1	1	-	-
Хулгай	3	8	4	6
Залилан	1	2	-	1
ХАБЭсрэг	4	-	1	3
Бусад	12	13	4	8
Бүгд	107	61	91	57
Дүнд эзлэх хувь	34.4	19.6	30.6	19.2

Зураг 12. Сogтyугаар болон гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг




2016 оны 4-р улирлын байдлаар согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 91 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 14.9 хувиар буюу 16 хэргээр буурсан нь тайлант хугацаанд бүртгэгдсэн хэргийн 30.6 хувийг эзэлж байгаа бөгөөд нийт гэмт хэрэгт эзлэх хувь өнгөрөгч оноос 3.8 пунктээр буурсан байна.

Мөн гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 57 болж өнгөрсөн оны мөн үеэс 6.5 хувиар

буюу 4 хэргээр буурсан бөгөөд нийт гэмт хэргийн 19.2 хувийг эзэлж байгаа нь өнгөрсөн оноос 0.4 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

2016 оны 4-р улирлын байдлаар гэмт хэрэгт 321 иргэн холбогдон шалгагдсаны 4.7 хувь буюу 15 нь 18 хүртлэх насны хүүхэд, 16.8 хувь буюу 54 нь эмэгтэйчүүд байна. Гэмт хэрэгт холбогдсон 18 хүртлэх насны хүүхэд өнгөрсөн оноос 46.4 хувиар буюу 13 хүүхдээр, эмэгтэйчүүд 15.6 хувиар буюу 10 хүнээр тус тус буурсан байна.

Зураг 13. Гэмт хэрэгт холбогдсон иргэдийн бүтэц



Хүснэгт 13. Гэмт хэрэгт холбогдсон хүмүүс

Үзүүлэлт	Хүний тоо		Өсөлт, бууралт	
	2015 он	2016 он	тоо	хувь
Гэмт хэрэгт холбогдсон хүн	373	321	-52	-13.9
Үүнээс: эмэгтэйчүүд	64	54	-10	-15.6
хүүхэд	28	15	-13	-46.4
Гэмт хэргийн улмаас хохирсон хүн	370	322	-48	-13.0
Үүнээс: нас барсан	38	28	-10	-26.3

гэмтсэн	175	180	5.0	2.9
Саатуулагдсан хүний тоо	1685	1763	78	4.6
Баривчлагдсан хүний тоо	188	78	-110	-58.5
Учирсан хохирол /сая төгрөг/	601.3	257.7	-343.6	-57.1
Нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ /сая төгрөг/	171.4	130.4	-41	-23.9

Тайлант хугацаанд 321 хүн гэмт хэргийн улмаас хохирсон ба үүнээс 180 хүн гэмтэж, 28 хүн нас барсан нь өнгөрсөн оны мөн үеэс гэмтсэн хүний тоо 2.9 хувиар буюу 5 хүнээр өссөн бол нас барсан хүний тоо 26.3 хувиар буюу 10 хүнээр буурсан байна. Мөн 1763 хүн саатуулагдаж, 78 хүн баривчлагдсан нь өнгөрсөн оны мөн үеэс саатуулагдсан хүний тоо 4.6 хувиар буюу 78 хүнээр өссөн бол, баривчлагдсан хүний тоо 2.4 дахин бага буюу 110 хүнээр буурсан байна.

Гэмт хэргийн улмаас 275.7 сая төгрөгийн хохирол учирсны 47.3 хувийг буюу 130.4 сая төгрөгийг нөхөн төлүүлжээ.

**БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД:** 2016 оны 12 сарын байдлаар дүүрэгт ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэд 579 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 1.7 хувиар буюу 10 хүнээр, эмэгтэй ажилгүй иргэд 307 байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.5 хувиар буюу 11 хүнээр тус тус буурсан байна. Тайлант сард ажил идэвхтэй хайж байгаа 7 хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна.

Зураг 14. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн хөдөлгөөн



Тайлант сард ажил идэвхтэй хайж байгаа 192 иргэн шинээр бүртгүүлсэн бөгөөд үүний 46.9 хувь нь буюу 90 нь эмэгтэйчүүд байна. Мөн энэ хугацаанд 10 иргэн ажилд зуучлуулан орсон байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн ажилд орсон байдлыг авч үзэхэд:


- хязгаарлагдмал хариуцлагатай компанид – 8
- төсөвт байгууллагад - 1
- бусад байгууллагад - 1 иргэн тус тус ажилд орсон байна.

Хүснэгт 14. Бүртгэлтэй ажилгүй иргэд, насны ангиллаар

Үзүүлэлт	2015 он	Дүнд эзлэх хувь	2016 он	Дүнд эзлэх хувь
15-24 нас	155	26.3	124	21.4
25-34 нас	242	41.1	221	38.2
35-44 нас	107	18.2	148	25.6
45-60 нас	85	14.4	86	14.9
Бүгд	589	100.0	579	100.0

2016 оны 12 сарын байдлаар ажил идэвхтэй хайж байгаа бүртгэлтэй ажилгүй иргэдийг насны ангиллаар авч үзэхэд 47.8 хувь нь 16-24 насны, 32.0 хувь нь 25-34 насны, 18.6 хувь нь 35-44 насны, 1.5 хувь нь 45-60 насны ажилгүй иргэд эзэлж байна.

Зураг 15. Бүртгэлтэй ажилгүй иргэд /насны бүлгээр/



Хүснэгт 15. Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролоор

Үзүүлэлт		Ажилгүй иргэд		Бүгдэд эзлэх хувь	
		2015 он	2016 он	2015 он	2016 он
Бүртгэлтэй ажилгүй иргэд		589	579	100.0	100.0
Үүнээс	Дээд	198	173	33.6	29.9
	Тусгай дунд	54	43	9.2	7.4
	Мэргэжлийн анхан шатны	58	62	9.8	10.7
	Бүрэн дунд	232	252	39.4	43.5
	Бүрэн бус дунд	30	34	5.1	5.9
	Бага	10	12	1.7	2.1
	Боловсролгүй	7	3	1.2	0.5

Зураг 16. Бүртгэлтэй ажилгүй иргэд /боловсролоор/



2016 оны 12 сарын байдлаар ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийг боловсролын түвшингээр ангилж үзэхэд 29.9 хувийг дээд, 7.4 хувийг тусгай дунд, 10.7 хувийг мэргэжлийн анхан шатны, 43.5 хувийг бүрэн дунд, 5.9 хувийг бүрэн бус дунд, 2.1 хувийг бага боловсролтой 0.5 хувийг боловсролгүй ажилгүй иргэд эзэлж байна.

**ҮНЭ ХАНШ:** 2016 оны 12 сарын хүнсний өргөн хэрэглээний 21 нэр төрлийн бүтээгдэхүүний дундаж үнийг ажиглахад доорх байдалтай байна.

Хүснэгт 16. Хүнсний барааны үнийн ажиглалт, 2016 оны 12 сарын дундаж үнэ


№	Хүнсний бараа	х.н	Хишиг-Уул супермаркет	Марал хүнсний дэлгүүр	Хэрлэн хүнсний зах	В&М супермаркет	Оранж супермаркет
1	"Алтан тариа" гурил	Дээд	кг	1350	1200	1300	1350
		I зэрэг	кг	1100	1100	1050	1150

	II зэрэг	кг	900	900		800	950	
2	Будаа	цагаан	кг	2200	2000		2200	2200
		шар	кг	1100	800		1700	1150
3	Хонины мах	ястай	кг		4500	5000		
		цул	кг		5500	6000		
4	Үхрийн мах	ястай	кг		5500	6000		
		цул	кг		6500	7000		
5	Адууны мах, ястай	кг		5500	5000			
6	Ямааны мах	кг		4500	5000			
7	Элсэн чихэр	кг	2300	2200		2300	2200	
8	Сүү миний монгол	Л	2350	2400		2300		
9	Тараг амтлаг	л	1650	1600		1700		
10	Цөцгийн тос, Орос	кг	3200	3500		3500	3100	
11	Байцаа	кг	1550	2000	2000	2000	2400	
12	Манжин	кг	1000	1600	800	1000	1050	
13	Төмс	монгол	кг	600	900	700	800	700
14	Лууван	монгол	кг	1700	1600	800	1000	700
15	Сонгино	хятад	кг	700	1600	1200	1500	1200
		монгол	кг	1800	2000	1800	2000	
16	Сармис, булцуу	кг	440	600	600	600	500	
17	Огурцы, хятад	кг	5500	5000	6000	6000	7900	
18	Помидор, хятад	кг	3000	5000	5000	6000	4600	
19	Ургамлын тос/ sunny gold/	ш	3500	3600		3800	3450	
20	Өндөг	ш	350	320		350	300	
21	Талх	том 900 гр	ш	1600	1600		1500	1500
		Дунд 700 гр	ш	1400	1300		1400	1100
		жижиг 500 гр	ш	1100	900		800	800
		Есөн шанд /жижиг/	ш	900	1100		900	850
		Атар талх	ш	1200	1100		1200	1150

Зураг 17. "Алтан тариа" гурилын үнэ / жил бүрийн 12 сар/



Зураг 18. Нэг кг махны үнэ /жил бүрийн 12 сар/



Хүснэгт 17. Үйлчилгээний үнийн тариф /НӨТ-гүй үнэ/

Үзүүлэлт	Айл өрхөд	Аж ахуйн нэгж байгууллагад
Дулаан	1 м <sup>2</sup> =522 төг	1м <sup>3</sup> =853 төг
Дулааны суурь тариф	40 м <sup>2</sup> хүртлэх=3000 төг	-
	40м <sup>2</sup> - 80м <sup>2</sup> = 5000 төг	
	81м <sup>2</sup> –аас дээш = 10000 төг	
Халуун ус	Өвөл 1 хүн=2500 төг /тоолуургүй/ 1м <sup>3</sup> =1187 төг /тоолууртай /	1гкал=54561 төг
	Зун 1 хүн=3500 төг /тоолуургүй/ 1м <sup>3</sup> =1187 төг /тоолууртай /	
Цэвэр ус*	1 хүн=5106 төг /тоолуургүй/	1 л=1.20 төг /тоолуургүй/
	1 л=0.63 төг /тоолууртай/	1 л=1.15 төг /тоолууртай/
	Суурь хураамж =1800 төг	1 л=4.41 төг /зөөврөөр/
Бохир ус*	1 хүн=4830 төг /тоолуургүй/	1 л=1.20 төг /тоолуургүй/
	1 л=0.58 төг /тоолууртай/	1 л=1.15 төг/тоолууртай/

\*2015 оны 1 сарын 10-наас мөрдөж байгаа тариф

Хүснэгт 18. Цахилгааны үнийн тариф /НӨТ-гүй үнэ/

Хэрэглэгчдийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
<b>* Айл өрхөд борлуулах цахилгааны тариф</b>		
Энгийн тоолууртай		
Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц	төг/квт.ц	98.4
Сарын нийт хэрэглээний 151 кВт.ц-аас дээш	төг/квт.ц	118.2
<b>2 тарифт тоолууртай</b>		
Өдрийн хэрэглээ /06.00-21.00/	төг/квт.ц	104.3
Орой, шөнийн хэрэглээ /21.00-06.00/	төг/квт.ц	77.1
<b>Сарын суурь тариф</b>	төг/сар	2000.0
<b>* Аж ахуйн нэгж, байгууллагад борлуулах цахилгааны тариф</b>		
Энгийн тоолууртай		
Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	128.5
Оройн хэрэглээ /17.00-24.00/	төг/квт.ц	209.8
Шөнийн хэрэглээ /24.00-06.00/	төг/квт.ц	77.1

3 тарифт тоолууртай /уул уурхай, үйлдвэрийн газар/		
Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	155.9
Оройн хэрэглээ /17.00-24.00/	төг/квт.ц	276.0
Шөнийн хэрэглээ /24.00-06.00/	төг/квт.ц	77.1

\* 2015 оны 7 сарын 25-ны өдрөөс мөрдөж буй тариф

Хүснэгт 19. Түлш шатахууны үнэ

Шатахууны нэр төрөл	2013 он	2014 он	2015 он	2016 он	өөрчлөлт	
					хувь	төгрөгөөр
АИ -76,80	1570	1560	1560	1440	-7.7	-120
АИ -92,93	1710	1700	1700	1540	-9.4	-160
Дизель түлш	1840	1830	1830	1650	-9.8	-180

2016 оны 12 сарын байдлаар түлш, шатахууны үнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулж үзэхэд 1 литр тутамдаа 7.7-с 9.8 хувиар буюу 120-180 төгрөгөөр буурсан байна.

Зураг 19. Хот хоорондын зорчигч тээврийн үнэ /УБ-БН, БН-УБ/



СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2017 оны 1 дүгээр сарын 9 өдөр